Эм зүйч, эм найруулагч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын эмпати ур чадварыг тодорхойлсон дүн

Б.Пүрэвжаргал[1], Д.Жамбанинж[1], П.Мандахнаран[1]

[1]АШУҮИС, Эм зүйн сургууль
Цахим шуудан: puujeebb5@gmail.com, Утас: 86013522

Түлхүүр үг:

Бусдыг ойлгох чадвар
Эм зүй
Мэргэжилтэн
Жефферсоны асуумж

Товч утга:

Үндэслэл: Дэлхий дахинд эм зүйн тусламж үйлчилгээний чиг хандлага өөрчлөгдөж эм зүйч нь эмчлүүлэгч төвтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багийн нэг гишүүн болж ажиллах болсон. Эмпати ур чадвар нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үндэс суурь болдог. АНУ-ын эм зүйн боловсролын магадлан итгэмжлэлийн зөвлөлөөс гаргасан стандартад эм зүйн сургалтын хөтөлбөрт эмпати ур чадварыг оруулсан ба ач холбогдлыг нь хүлээн зөвшөөрч, эмчлүүлэгч төвтэй эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг гэж үзсэн байна. Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр суралцаж буй оюутнуудад эмпати ур чадварыг хөгжүүлэх нь чухал юм. Монгол улсад эм зүйч болон эм зүйн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын эмпати чадварын талаар хийгдсэн судалгаа хийгдээгүй байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо. **Зорилго:** Эм зүйн мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын эмпати ур чадварыг үнэлэх. **Арга, аргачлал:** Судалгаанд АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийн эм зүйч, эм найруулагч хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудыг хамруулан дескриптив судалгааны нэг агшингийн загвараар асуумжийн аргаар хийж гүйцэтгэсэн. Судалгаандаа Олон улсын эрүүл мэндийн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын эмпатиг үнэлдэг JSE-HPS асуумжийг ашигласан. Судалгааны мэдээллийг Microsoft Excel программаар нэгтгэж, үр дүнд SPSS-26 программыг ашиглаж, статистик боловсруулалтыг хийлээ. **Үр дүн:** Судалгаанд оролцогчдыг суралцаж буй мэргэжлийн хөтөлбөрөөр нь ангилж үзэхэд эм зүйч (2+3) хөтөлбөрөөр суралцагч 55.17% (80), эм зүйч (3+3) хөтөлбөрөөр суралцагч 17.2% (25), эм найруулагч хөтөлбөрөөр суралцагч 27.6% (40) эзэлж байв. Судалгаанд хамрагдагсдын нас 18-40 жил, дундаж нас 22 (90) жил, хүйсийн хувьд дийлэнх нь буюу 91.7% (133) нь эмэгтэй оюутан эзэлж байв. Судалгаанд хамрагдагсдын дундаж оноог асуулт тус бүрээр нь авч харьцуулж үзэхэд эмпати ур чадвар нь үйлчлүүлэгчдийн эмчилгээнд чухал хүчин зүйл болдог гэдэгт би итгэдэг (Асуулт 5) үзүүлэлтийн дундаж оноо хамгийн өндөр байна. Мөн үйлчлүүлэгчээс амьдралд нь юу тохиолдсоныг асуух нь биеийн байдлыг ойлгоход тус болдог (Асуулт 11) гэсэн асуултуудад хариулсан нь эм зүйч (2+3) хөтөлбөрийн оюутнууд 3.34 буюу хамгийн өндөр оноог, эм зүйч (3+3) хөтөлбөрийн оюутнууд 3.0 оноо, эм найруулагч хөтөлбөрийн оюутнууд хамгийн бага буюу 2.53 оноог өгсөн байна ($p<0.01$). Нийт оноог нас, хүйс, гэрлэлтийн байдалтай харьцуулахад статистик ач холбогдол бүхий өөрчлөлтгүй байгаа нь ($p<0.909$) тодорхойлогдлоо. **Дүгнэлт:** 1. АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийн эм зүйн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрөөр суралцаж байгаа төгсөх дамжааны оюутнуудын эмпати чадварыг JSE-HPS –ийн асуумжаар авсан судалгааны дүнгээс харахад оюутнуудын эмпати чадвар харилцан адилгүй тархацтай бөгөөд цаашид энэ чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. 2. Оюутнуудын эмпати чадвар нь нас, хүйс, гэрлэлтийн байдалтай урвуу хамааралтай байна.

Үндэслэл: Дэлхий дахинд эм зүйн тусламж үйлчилгээний чиг хандлага өөрчлөгдөж эм зүйч нь эмчлүүлэгч төвтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багийн нэг гишүүн болж ажиллах болсон.[1] Эмпати ур чадвар нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үндэс суурь болдог.[2] АНУ-ын эм зүйн боловсролын магадлан итгэмжлэлийн зөвлөлөөс гаргасан стандартад эм зүйн сургалтын хөтөлбөрт эмпати ур чадварыг оруулсан ба ач холбогдлыг нь хүлээн зөвшөөрч, эмчлүүлэгч төвтэй эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг гэж үзсэн байна.[3] Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр суралцаж буй оюутнуудад эмпати ур чадварыг хөгжүүлэх нь чухал юм.[4] Монгол улсад эм зүйч болон эм зүйн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын эмпати чадварын талаар хийгдсэн судалгаа хийгдээгүй байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго: Эм зүйн мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын эмпати ур чадварыг үнэлэх

Зорилт:

1. Эм зүйч, эм найруулагч хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудын эмпати ур чадварыг тодорхойлох
2. Оюутнуудын эмпати ур чадварыг хооронд нь харьцуулах

Арга, аргачлал: Судалгаанд АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийн эм зүйч, эм найруулагч хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудыг хамруулан дескриптив судалгааны нэг агшингийн загвараар асуумжийн аргаар хийж гүйцэтгэсэн.

Олон улсын эрүүл мэндийн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын эмпати ур чадварыг үнэлэх (JSE-HPS Jefferson Scale of Emphaty Health Profession Students) асуумжийг ашигласан. Энэхүү асуумж нь «Огт үнэн биш»-ээс «Маш үнэн» хүртэл 5 оноотой 20 асуулт бүхий Likert -ийн шалгуураар үнэлэв. Судалгаанд нас, хүйс, гэрлэсэн байдал зэрэг хувь хүний онцлог шинж чанаруудыг эмпатийн онооны дундаж ялгааг харьцуулах асуултуудыг оруулсан бөгөөд асуумжийн найдвартай байдлыг (Cronbach's alpha coefficient) кронбах альфа ашиглан шалгаж үзэхэд 0.805 байв. Судалгааны мэдээллийг Microsoft Excel программаар нэгтгэж, үр дүнд SPSS-26 программыг ашиглаж, статистик боловсруулалтыг хийлээ. Судалгааг АШУҮИС-ийн Судалгааны Ёс зүйн хяналтын хорооны (Протокол №2023/3-04) зөвшөөрөлтэйгөөр хийсэн.

Үр дүн: Судалгаанд эм зүйн мэргэжлээр суралцаж байгаа 145 оюутан хамрагдсан (Хүснэгт 1). Судалгаанд оролцогчдын нас 18-40 ба дундаж нас 22 (90), судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 91.7% (133) нь эмэгтэй оюутнууд эзэлж байсан.

Хүснэгт 1. Судалгаанд оролцсон эм зүйн мэргэжлээр суралцаж буй оюутнуудын тоо

Хөтөлбөр	Тоо (N)	Хувь (%)
Эм зүйч (2+3 жил)	80	55.17
Эм зүйч (3+3 жил)	25	17.2
Эм найруулагч (3 жил)	40	27.6
Нийт	**145**	**100.0**

Судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогчдын эмпати ур чадварын дундаж утга 70.124, стандарт хазайлт 10.708, медиан 71 байв. Судалгаанд оролцсон дийлэнх оюутнуудын эмпати түвшинг Ликертийн үнэлгээгээр хэмжихэо 3.5 дээш оноотой байсан. Судалгаанд оролцогчид 1, 2, 3, 4, 5, 6, 9, 10, 14, 17, 19-р асуултанд ≥3.5 оноо өгсөн байв. Эмпати ур чадвар нь үйлчлүүлэгчдийн эмчилгээнд чухал хүчин зүйл болдог гэдэгт би итгэдэг (Асуулт 5) асуултад эм зүйч (2+3) хөтөлбөрийн оюутнууд 4.27±0.90, эм зүйч (3+3) хөтөлбөрийн оюутнууд 4.0±0.96, эм найруулагч хөтөлбөрийн оюутнууд 4.10±1.08 оноо гэж хариулсан нь хамгийн өндөр байв. (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын эмпати чадварыг хөтөлбөрөөр харьцуулсан дүн (≥3.5оноо)

Асуулт	Эм зүйч 2+3 /N=80/			Эм зүйч 3+3			Эм найруулагч			P утга
	N	Mean	St.dev	N	Mean	St.dev	N	Mean	St.dev	
Бусдыг ойлгох нь эмчилгээ, харилцааны ур чадвар бөгөөд түүнгүйгээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд хязгаарлагдмал байдаг.	80	4.10	1.01	25	4.04	1.34	40	4.08	1.10	0.97
Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн харилцаа хандлагыг үнэлдэг бөгөөд энэ нь эмчилгээний чанарт нөлөөлдөг.	80	4.00	1.07	25	3.52	1.00	40	4.20	1.20	0.05
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид үйлчлүүлэгч болон гэр бүлийхнийг ойлгох нь сэтгэл хөдлөлийн харилцааны чухал бүрэлдэхүүн мөн.	80	3.81	1.10	25	3.80	1.22	40	3.93	1.14	0.86
Эрүүл мэндийн ажилтнууд үйлчлүүлэгчийнхээ сэтгэл хөдлөлийг ойлгож байгааг үйлчлүүлэгчид илүү сайн мэдэрдэг.	80	3.86	0.99	25	3.80	0.91	40	3.88	1.11	0.95
Бусдыг ойлгох ур чадвар нь үйлчлүүлэгчдийн эмчилгээнд чухал хүчин зүйл болдог гэдэгт би итгэдэг.	79	4.27	0.90	25	4.00	0.96	40	4.10	1.08	0.42
Үйлчлүүлэгчийн эмийн эмчилгээнд сэтгэл хөдлөл нөлөөлдөг.	80	3.51	1.29	25	3.92	1.29	40	3.30	1.11	0.15
Биеийн хэлэмжийг ойлгох нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд харилцаанд маш чухал.	80	3.88	1.00	25	3.48	0.96	40	3.93	1.16	0.20
Эрүүл мэндийн ажилтнууд үйлчлүүлэгчид тусламж үзүүлэхдээ тэдний оронд өөрийгөө тавьж үзэх нь чухал хэрэгтэй.	80	3.93	1.04	25	3.40	0.96	40	3.68	1.25	0.09
Үйлчлүүлэгчтэй ярилцах үед үйлчлүүлэгчийн сэтгэл хөдлөл чухал юм.	79	3.58	1.02	23	3.83	0.83	40	3.75	1.13	0.51
Эрүүл мэндийн мэргэжилтнүүд үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлийн гишүүдийн хооронд хувийн, дотно харилцаа үүсгэхийг зөвшөөрнө.	80	3.71	1.29	25	2.68	1.25	40	3.35	1.48	0.00
Хүн бүрийн ялгаатай байдлыг ойлгох нь чухал юм.	79	4.04	1.03	25	3.80	1.22	40	4.08	1.07	0.56

Судалгаанд оролцогчид 7, 8, 11, 12, 13, 15, 16, 18, 20-р асуултанд ≥3.5 оноо өгсөн байна. Эмпати ур чадвар нь үйлчлүүлэгчээс амьдралд юу тохиолдсоныг асуух нь биеийн байдлыг ойлгоход тус болдог (Асуулт 11) асуултад хариулсан дүнгээс харахад эм зүйч (2+3) хөтөлбөрийн оюутнууд 3.34±1.18 буюу хамгийн өндөр оноог, эм зүйч (3+3) хөтөлбөрийн оюутнууд 3.0±1.41 оноо, эм найруулагч хөтөлбөрийн оюутнууд хамгийн бага буюу 2.53±1.29 оноог өгсөн байна ($p<0.01$). (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын эмпати чадварыг хөтөлбөрөөр харьцуулсан дүн (≤3.5оноо)

Асуулт	Эм зүйч 2+3 /N=80/			Эм зүйч 3+3			Эм найруулагч			P Утга
	N	Mean	St.dev	N	Mean	St.dev	N	Mean	St.dev	
Эмнэлэгийн нөхцөлд үйлчлүүлэгчийн эмчилгээнд сэтгэл хөдлөл ямар ч нөлөө үзүүлдэггүй гэдэгт би итгэдэг.	78	3.41	1.26	24	3.71	1.33	40	3.10	1.32	0.18
Үйлчлүүлэгчээс хувийн амьдралынх нь талаар асуух нь тэдний биеийн байдлыг ойлгоход тус болдог.	80	3.15	1.18	25	2.88	1.17	40	3.48	1.13	0.12
Үйлчлүүлэгчээс амьдралд нь юу тохиолдсоныг асуух нь биеийн байдлыг ойлгоход тус болдог.	80	3.34	1.18	25	3.00	1.41	40	2.63	1.29	0.01
Үйлчлүүлэгчийн болон тэдний гэр бүлийн хүмүүсийн мэдрэмжийг ойлгох нь эмчилгээний үр дүнд нөлөөлдөг.	80	3.14	1.16	25	3.20	1.35	40	3.33	1.19	0.72
Үйлчлүүлэгчийн хувийн амьдралд анхаарал хандуулах нь эмчилгээний үр дүнд нөлөөлдөг.	80	2.73	1.04	25	3.04	1.49	40	2.90	1.30	0.47
Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн сэтгэл хөдлөл нь эмчилгээний үр дүнд нөлөө үзүүлнэ.	79	3.37	1.18	23	3.70	0.76	40	3.63	1.03	0.29
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн хошин шогийн мэдрэмж нь эмчилгээний үр дүнг сайжруулахад нөлөөлдөг.	80	3.08	1.23	25	3.60	0.76	40	3.15	1.23	0.14
Анагаахын бус болон урлагийн ном унших нь надад таалагддаг.	80	3.23	1.10	25	3.68	1.03	40	3.13	1.30	0.14
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн хувьд аливаа зүйлийг үйлчлүүлэгчийн өнцгөөс харахад хэцүү байдаг.	80	2.51	1.15	25	2.96	1.34	40	2.63	1.13	0.25

Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдлыг авч үзэхэд 60% (87) ганц бие, 29.7% (43) гэрлэсэн, 10.3% (15) бусад гэж хариулсан байна. Нийт оноог нас, хүйс, гэрлэлтийн байдал хэрхэн нөлөөлж буйг харьцуулан судлахад статистик ач холбогдол бүхий өөрчлөлтгүй байгаа нь ($p<0.909$) харагдаж байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Эмпати нийт оноонд нас, хүйс, гэрлэлтийн байдал нөлөөлөх нь

Хамаарал	Нийлбэр квадрат	Чөлөөний зэрэг	Дундаж квадрат	Тархалтын утга	P утга
Нас * Нийт оноо	670.775	42	15.971	1.704	0.016
Хүйс * Нийт оноо	3.775	42	0.090	1.268	0.168
Гэрлэлт * Нийт оноо	25.726	42	0.613	1.542	0.040

Нийт 20 асуумжийг Factor correlation-ны хүчин зүйл тус бүрээр нь хэтийн төлөв, энэрэнгүй нигүүлсэнгүй чанар, үйлчүүлэгчийн оронд өөрийгөө тавих, хувь хүний хүчин зүйл гэсэн 4 хүчин зүйлд хуваан авч үзэв. Хэтийн төлөвийг тодорхойлох гол хүчин зүйл баруун тийш буюу 3.88 байгаа нь цаашид эмпати чадвар нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна. Энэрэнгүй нигүүлсэнгүй чанарын дундаж 3 оноо байсан ба тархалт харилцан адилгүй байгаа нь цаашид энэ чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Харин үйлчлүүлэгчийн оронд өөрийгөө тавьж үзэх чадвар 3.45, хувь хүний хүчин зүйл 3.23 байгаа нь дундаж түвшинд байна.

Хэлцэмж: Дэлхийн ихэнх улс орнуудад эрүүл мэндийн чиглэлээр суралцах оюутнуудаас элсэлтийн шалгалтаас гадна PS, JST болон MMI аргаар эмпати чадварыг үнэлж сургуульд элсүүлдэг бөгөөд тухайн оюутныг их сургуулиа төгсөхөд мөн эмпати чанарыг үнэлж дүгнэдэг байна[3]. Харин манай орны хувьд одоогоор эрүүл мэндийн чиглэлээр суралцахаар элсэн орж байгаа элсэгчдээс энэ төрлийн шалгалт, асуумж авч эхлээгүй байна.

Олон улсад JSE-HPS-ийн асуумжийг эрүүл мэндийн чиглэлээр суралцаж буй оюутнуудын эмпати ур чадварыг тодорхойлоход ашигладаг бөгөөд бид энэхүү асуумжийг ашигласнаар бусад судлаачдын үр дүнтэй өөрсдийн судалгааны үр дүнг харьцуулахад дөхөм байсан[5].

Судлаач Soohyun Jeon (2015) нарын хийсэн судалгааны үр дүнгээс үзвэл эм зүйч мэргэжлээр суралцаж буй 452 оюутны 18% (81) нь эрэгтэй байсан бол бидний Монгол улсад хийсэн судалгаагаар 8.3% (12) эрэгтэй оюутан байгаа нь эм зүйн мэргэжлээр суралцаж байгаа эрэгтэй оюутнуудын эзлэх хувь адилхан бага байгааг харуулж байна. Мөн тус судалгаагаар хүйс, суралцсан жил нь эмпатийн хувьд ямар ч ач холбогдолгүй байсан нь[6-8] манай судалгааны

үр дүнтэй ижил байна.

Hojat M (2009) нарын судлаачид эмпати байдалд хүйсийн ялгаа их бөгөөд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс илүү эмпатик, анагаахын сургалтад хамрагдсан хугацаандаа эрэгтэйчүүдээс илүү өрөвдөх сэтгэлтэй байгааг тогтоосон бөгөөд[9] бидний судалгаагаар эрэгтэйчүүдийг эмэгтэйчүүдтэй харьцуулахад арай илүү өндөр оноо авсан байгаа ч статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй нь судалгаанаас харагдаж байсан.

Эрүүл мэндийн мэргэжлээр суралцаж буй оюутнууд (эм зүй, сувилахуй) болон эрүүл мэндийн бус мэргэжлээр суралцаж буй оюутнууд (хууль)-ын хоорондын эмпатик сэтгэлийн оноог харьцуулах зорилгоор хийсэн Sarah E (2012) нарын судалгааны дүнгээс харахад сувилахуйн болон эм зүйн оюутнууд хуулийн оюутнуудаас харьцангуй илүү өрөвдөх сэтгэлтэй байсан байна.[9] Харин эм зүйн гуравдугаар дамжааны оюутнууд нэгдүгээр дамжааны оюутнуудаас өндөр оноотой байсан бол сувилагч нарын хувьд эсрэгээрээ, хуулийн ангийн 1, 3-р курсын оюутнуудын дунд эмпати мэдэгдэхүйц ялгаагүй байгааг тогтоосон байна [9].

Бид судалгаандаа зөвхөн эм зүйн мэргэжлээр суралцаж байгаа төгсөх дамжааны оюутнуудыг хамруулсан нь цаашид нэгдүгээр дамжааны оюутнууд болон бусад эрүүл мэндийн чиглэлийн оюутнуудтай харьцуулан судлах шаардлагатай байгааг харуулж байна.

Дүгнэлт:

1. АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийн эм зүйн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрөөр суралцаж байгаа төгсөх дамжааны оюутнуудын эмпати чадварыг JSE-HPS –ийн асуумжаар авсан судалгааны дүнгээс харахад оюутнуудын эмпати чадвар харилцан адилгүй тархацтай бөгөөд цаашид энэ чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
2. Оюутнуудын эмпати чадвар нь нас, хүйс, гэрлэлтийн байдалтай урвуу хамааралтай байна.

Талархал: Судалгаанд хамрагдсан эм зүйн хөтөлбөрөөр суралцаж буй оюутнууддаа талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Hale Zerrin Toklu, Azhar Hussain. The changing face of pharmacy practice and the need for a new model of pharmacy education. J Young Pharm, 2013 Jun;5(2):38-40. doi: 10.1016/j. jyp.2012.09.001. Epub 2013 Mar 30.*
2. *Spiro H. The practice of empathy. Acad Med. 2009;84(9):1177-1179.*
3. *Accreditation Standards and Guidelines for the Professional Program in Pharmacy Leading to the Doctor of Pharmacy Degree. Accreditation Council for Pharmacy Education. Released February 17, 2006. http://www.acpe-accredit.org/pdf/*
4. *Larson EB, Yao X. Clinical empathy as emotional labor in the patient-physician relationship. JAMA. 2005;293(9):1100-1106.*
5. *Soohyun Jeon, Eun Cho. Assessment of Korean Pharmacy Students' Empathy Using the Jefferson Scale of Empathy, American Journal of Pharmaceutical Education 2015; 79 (5) Article 67*
6. *Soohyun Jeon, Eun Cho. Assessment of Korean Pharmacy Students' Empathy Using the Jefferson Scale of Empathy, American Journal of Pharmaceutical Education 2015; 79 (5) Article 67.*
7. *Hojat M, Vergare MJ, Maxwell K, et al. The devil is in the third year: a longitudinal study of erosion of empathy in medical school. Acad Med. 2009;84(9):1182-1191.*
8. *Sarah E. Wilson, Julie Prescott, Gordon Becket. Empathy Levels in First- and Third-Year Students in Health and Non-Health Disciplines. American Journal of Pharmaceutical Education 2012; 76 (2) Article 24.*
9. *Sarah E. Wilson, Julie Prescott, Gordon Becket. Empathy Levels in First- and Third-Year Students in Health and Non-Health Disciplines. American Journal of Pharmaceutical Education 2012; 76 (2) Article 24.*
10. *Kaplan SH, Greenfield S, Ware JE. Assessing the effects of physician-patient interactions on the outcomes of chronic disease. Med Care. 1989;27(3 Suppl):S110-S127.*
11. *Reiss H., "Empathy in medicine: a neurological perspective". JAMA. 2010;304(14):1604-1605.*
12. *Newton BW, Barber L, Clardy J, Cleveland E, O'Sullivan P., "Is there hardening of the heart during medical school. Acad Med. 2008;83(3):244-249.*
13. *Berg K, Majdan JF, Berg D, Veloski J, Hojat M., "Medical students' self-reported empathy and simulated patients' assessments of student empathy: an analysis by gender and ethnicity". Acad Med. 2011;86 (8):984-988.*
14. *Glaser KM, Markham FW, Adler HM, McManus PR, Hojat M., "Relationships between scores on the Jefferson Scale of physician empathy, patient perceptions of physician empathy and humanistic approaches to patient care: a validity study". Med Sci Monit. 2007;13 (7):CR291-294.*
15. *Hojat M, Mangione S, Kane GC, Gonnella JS., "Relationships between scores of the Jefferson Scale of Physician Empathy (JSPE) and the Interpersonal Reactivity Index (IRI)". Med Teach. Nov 2005; 27(7):625-8.*
16. *Roh MS, Hahm BJ, Lee DH, Suh DH., "Evaluation of empathy among Korean medical students: a cross-sectional study using the Korean Version of the Jefferson Scale of Physician Empathy". Teach Learn Med. 2010;22(3):167-71.*

Results of empathy in pharmacy and pharmacy technician students

Purevjargal B[1], Jambaninj D[1], Mandakhnaran P[1]

[1]School of Pharmacy, MNUMS
E-mail puujeebb5@gmail.com, Tel: +976-86013522

Background: Global trends in pharmaceutical care are changing, with pharmacists working as a member of a physician-centered healthcare team. Empathy skills are fundamental to healthcare delivery. The US Accreditation Council for Pharmacy Education In the released standards, empathy skills were included in the pharmacy curriculum, and its importance was recognized and it was considered that it contributes significantly to the provision of patient-centered pharmaceutical care. It is important to develop empathy skills for students studying medicine and healthcare. In Mongolia, there has been no research on the empathy ability of pharmacists and students studying pharmacy, which is the reason for conducting this research.
Aim: To assess the empathy skills of students studying pharmacy.
Materials and Methods: The study was conducted by a descriptive research method using a single-moment model of descriptive research involving students studying as a pharmacist and drug director program of the School of Pharmacy of MNUMS. The JSE-HPS questionnaire, which assesses empathy among International Health students, was used in the study. The research data was compiled using Microsoft Excel, and SPSS-26 software was used for statistical processing.
Results: When the respondents were classified by their professional program, 55.17% (80) were students of the pharmacist (2+3) program, 17.2% (25) were students of the pharmacist (3+3) program, and 27.6% (40) were students of the pharmacy technician program occupied. The age of the respondents was 18-40, the average age was 22 (90), and the majority of the respondents, 91.7% (133), were female students. When comparing the mean scores of the respondents for each question, the mean score for the indicator I believe that empathy skills are an important factor in the treatment of clients (Question 5) is the highest. Also, according to the answers to the question that asking the client what happened in his life helps to understand the condition (Question 11), students of the pharmacist (2+3) program scored 3.34, the highest score, students of the pharmacist (3+3) program scored 3.0 points, director program students gave the lowest score of 2.53 ($p<0.01$). The study shows that there is no statistically significant change in the total score compared to age, gender, and marital status ($p<0.909$).
Conclusions: According to the results of the JSE-HPS questionnaire, the empathy skills of the students studying in the pharmaceutical specialist training program of the School of Pharmacy of MNUMS have different distributions and are inversely related to age, gender, and marital status need to increase.

Kewwords: Empathy, Pharmacy, Professional, Jefferson Scale of Emphaty